



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн Р-2023-62 дугаар тогтоолын Хавсралт



ХАСБАНКНЫ ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
2023-2026

Монгол Улс, Улаанбаатар хот

Танилцуулга:

Тус төлөвлөгөөний зорилго нь СЗХ-ны Компанийн Засаглалын кодекст тусгасан зөвлөмж болон удирдамжийн дагуу компанийн засаглалын үйл ажиллагааг уялдуулахад шаардлагатай стратегийн хөтөч болоход оршино.

Д	Үндсэн чиглэл	Арга хэмжээ/Тайлбар	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
Төлөөлөн удирдах зөвлөлийн түвшний засаглал				
1	ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний бодлого журам болон үнэлгээний маягыг сайжруулах	ТУЗ нь жилээр дэлгэрэнгүй үнэлгээ хийх журмыг одоогоор баримтлан хэрэгжүүлж байгаа. Шинэ ХК болон өөрчлөгдсөнөөр 2024 оны I улиралд бодлогыг шинэчлэнэ.	2024 оны I улирал	Дарга/ЗНДЦУХ-ны дарга/ТУЗ-ийн НБД
2	Хүйсийн тэнцвэрт байдлыг хангах	Хүйсийн төлөөлөл тус бүр багадаа 30% байна. Одоогийн байдлаар, ТУЗ-ийн эмэгтэй гишүүд нийт гишүүдийн 27%-ийг эзэлж байгаа болно. Бид 2025 оны 4 дүгээр сар гэхэд 30% хүргэхээр ажиллана.	2025 оны II улирал	ЗНДЦУХ
3	Дарга хараат бус байх	Хэлэлцүүлэг/төлөвлөгөө.	2026 оны IV улирал	ЗНДЦУХ
4	Хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнийг олонх байлгах	Хэлэлцүүлэг/төлөвлөгөө.	2026 оны IV улирал	ЗНДЦУХ
5	ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр	ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг тодорхойлж хэрэгжүүлнэ. Уг хөтөлбөр нь компанийн эрсдэлийн үнэлгээний элементийг агуулсан байхаас гадна хараат бус гишүүдэд тусгайлсан сургалт зохион байгуулна.	2024 оны II улирал	ЗНДЦУХ
6	Эрсдэлийн удирдлагын хорооны болон ЗНДЦУХ-ийн даргаар Хараат бус гишүүнийг ажиллуулах	Хараат бус гишүүдийг Эрсдэлийн удирдлагын хорооны болон ЗНДЦУХ-г даргалахад бэлтгэнэ.	2025 оны II улирал	ЗНДЦУХ
7	Банкны эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан урамшууллын бодлого хэрэгжүүлэх	Боловсруулна.	2025 оны II улирал	ЗНДЦУХ
8	Ажилтнуудад зориулсан урамшууллын бодлого хэрэгжүүлэх	Боловсруулж байна.	2024 оны II улирал	ЗНДЦУХ
9	Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого	Банк залгамж халааг бэлдэх бодлоготой бөгөөд жил бүр хэрэгжилтийг хянадаг. Гэхдээ, илүү зохион байгуулалттай бүтцийн арга барил төлөвшүүлэх үүднээс Банк Залгамж халааг бэлдэх журмыг (Төлөвлөгөөнөөс тусдаа) батална.	2024 оны III улирал	
10	ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааг бэлдэх бодлого	Боловсруулна.	2025 оны II улирал	
11	Оролцогч талуудын мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс тусгай пэйж боловсруулах	Боловсруулж байна.	2023 оны IV улирал	ТУЗ-ийн НБД
12	Оролцогч талуудтай харилцах хөтөлбөр	- Оролцогч талуудын сонирхол, хэрэгцээг тодорхойлох, - Харилцаа холбоо, хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлох ажлуудыг хийнэ.	2024 оны III улирал	ТУЗ-ийн НБД